| 210401 | Бичиг хэрэг | 11,707,670.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,649,360.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 105,520.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,883,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 68,024,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,699,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 63,324,450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,805,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,805,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,718,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,629,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 89,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 321801.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 321,801.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,349,365.08** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 121232373.08 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 121,232,373.08 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 24,485,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 96,246,573.08 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот, байгууламтын газар */цаашид ГХБХБГ гэх/* нь "*Сэлэнгэ аймгийн газар нутгийн нөөц чадавхыг дэмжин тэтгэсэн эдийн засгийн хувьд ашигтай, экологийн хувьд тэнцвэртэй газар ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, эрх зүйн баталгаатай газар өмчлөл, эзэмшилт, ашиглалтыг бий болгоно* " гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Барилгын захиалагчийн хяналтын талаар авах арга хэмжээний тухай" 83 дугаар тушаалаар барилга байгууламжийн захиалагчийн хяналтын орлогоос санхүүжүүлэх зардлын нэр төрлийг баталсан гэх мэт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

ГХБХБГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд Барилга хот байгуулалтын яамны "Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс"-ээс хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГХБХБГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Газрын харилцаа барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 384 дүгээр тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлого горим”-ыг баталсан байна.

Уг НББББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2012 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ГХБХБГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106,832.5 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 4,575.9 | 1,238.8 | -3,337.1 |
| Бараа материал | 52,462.7 | 33,760.3 | -18,702.4 |
| Үндсэн хөрөнгө | 466,732.5 | 381,939.6 | -84,793.0 |
| **Нийт хөрөнгө** | **523,771.2** | **416,938.7** | **-106,832.5** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 523,771.2 | 416,938.7 | -106,832.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **523,771.2** | **416,938.7** | **-106,832.5** |

Өмнөх оны эцэст тайлагнагдсан 4,575.9 мянган төгрөгийн авлагаас 3,337.1 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага нь тайлант онд бүрэн барагдаж, нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Угантуяатай холбоотойгоор 2012 онд үүссэн 1,238.8 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,760.3 мянган төгрөг болж 18,702.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 96,047.5 мянган төгрөгийн материал худалдан авч, ГЗБГЗЗГ-аас 235.6 мянган төгрөгийн хэвлэмэл гарын авлага болон шатахуун худалдан авалтын гэрээний урамшуулал 1,189.0 мянган төгрөгийн талон үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 98,136.9 мянган төгрөгийн материалыг зарцуулсан бөгөөд ГЗБГЗЗГ-т 4,306.7 мянган төгрөгийн үнэт цаасыг шилжүүлэн өгч, 13,730.9 мянган төгрөгийн бараа материалыг актлаж, устгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 703,189.1 мянган төгрөг болж 125,553.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 10,859.7 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авч, ГЗБГЗЗГ-аас 4,675.3 мянган төгрөгийн компьютер, Барилга хот байгуулалтын яаманд хэрэгжиж буй төслөөс 5,860.0 мянган төгрөгийн дулаан хэмжигч багажийг үнэ төлбөргүй тус тус шилжүүлэн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны А-1/2222 дугаар албан бичгээр 146,948.6 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 416,938.7 мянган төгрөг болж 106,832.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,997,091.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2,459,107.0 мянган төгрөгийг бууруулж */Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 103,443.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 26,155.8 мянган төгрөгөөр байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 28,605.1 мянган төгрөгөөр тус тус бууруулж, , бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний бусад зардлыг 200,903.1 мянган төгрөгөөр, шинээр баригдахаар төлөвлөсөн лабораторийн барилгын 2.100,000.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна./* 537,984.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 537,984.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр улсын төсвөөс 537,984.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 532,508.3 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 3,782.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшлын зардал 64.5 мянган төгрөгөөр, барилгын техник хяналт 1,629.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 512,011.7 | 508,229.0 | 3,782.7 | 99.2 |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшил | 3,014.5 | 2,950.0 | 64.5 | 97.8 |
| 3 | Барилгын техник хяналт | 22,958.3 | 21,329.3 | 1,629.0 | 92.9 |
| | **Дүн** | **537,984.5** | **532,508.3** | **5,476.2** | **98.8** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130029401 тоот дансанд нийт 121,232.4 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрч, 119,060.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 2,171.9 мянган төгрөгийг ГЗБГЗЗГ-т төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ЗДНХ-өөс 2022 оны 10 сарын 24-ны А/453 дугаар захирамжаар Сэлэнгэ аймгийн тариалангийн талбайн тооллогын ажлыг санхүүжүүлэхээр 24,485.8 мянган төгрөг,
- ГЗБГЗЗГ-аас 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр тусгай байранд шалгарсан тул шагналын 500.0 мянган төгрөг,
- 2021 оны жилийн эцэст төсөвт төвлөрүүлсэн орлогын буцаан олголтын 3,337.2 мянган төгрөг,
- Иргэдээс эзэмшил газрын эргэлтийн цэг тогтоолгосны төлбөрийн орлого 1,410.0 мянган төгрөг,
- Цахим тендерийн урилгын 140.0 мянган төгрөг,
- Барилгын техник хяналтын захиалагчийн хяналтын орлогоос 91,359.7 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу ГХБХБГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын зардлыг тухайн оны төсөвт тусгаж, олгох, бараа материалыг холбогдох стандартын дагуу бүртгэх, ӨХБЗ-ийн хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны бүрдүүлж ажил гүйлгээг гүйцэтгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ГХБХБГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 815,534.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,155.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны 1/948 дугаар "Төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлж ажиллах" албан бичгийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна. Үүнд:

- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*

- *Тээвэр шатахуун, хичээл сургалт үйлдвэрлэлийн зардлыг хэмнэх зорилгоор сумдын газрын даамлуудын сургалт, уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан,*

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ГХБХБГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

ГХБХБГ нь төрийн албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын зардлыг тухайн оны төсөвт тусгаж батлуулаагүйгээс албан хаагчдын улирлын ажлын мөнгөн урамшууллыг улирал бүр олгоогүй байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.3-д *“Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана”* гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн:* Албан хаагчдын улирлын ажлын мөнгөн урамшууллын зардлыг төсөвт тусган батлуулж, олгож байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бол албан хаагчдад олгох мөнгөн урамшууллыг төсөвт тусгаж, батлуулаагүй байгаа нь Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

**2.** Барилгын техник хяналтын ажилд зарцуулагдах зардлыг */гэрээт ажилтны цалин, НДШ, бичиг хэрэг, шуудан холбоо, албан томилолт, шатахуун, сургалт/* зардлын ангилал нэр төрлөөр бус бусдаар гүйцэтгүүлсэн бусад үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлыг бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд барилгын техник хяналтын ажилд зарцуулагдах төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад дараах 22,527.6 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг 1,739.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Тээвэр шатахууны зардлыг 9,524.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 11,263.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Аудитаар нийт **1,238.8** мянган төгрөгийн зөрчил илэрч, 1 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд бараа материалын бүртгэлтэй холбоотой 1 зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага

**1.1** *Илрүүлэлт:* Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 1,238.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулаагүй, найдваргүй гэж үзвэл данс бүртгэлээс хасах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.-д "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах*, ..... гэсэн заалтыг зөрчсөн байна.

**1.2** *Шийдвэрлэсэн нь*: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*", 4.2.1.10: "*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

**1.1**. *Илрүүлэлт* Бараа материалыг ангиллын дагуу бус сэлбэг хэрэгсэл, хүнсний материал, барилгын засварын материалыг аж ахуйн материалд бүртгэн тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь "*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж,*

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоогдож, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулах, авлага барагдуулах зэрэг 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн авлага барагдуулах 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 778.0 | 1 | 778.0 | 100 |
| Зөвлөмж | 3 | 15,425.2 | 2 | 14,186.4 | 66.6 |
| **Нийт дүн** | **4** | **16,203.2** | **3** | **14,964.4** | **75.0** |

Өмнөх аудитаар өгсөн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: *"Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжих дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

**1**. Газрын харилцаа барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 384 дүгээр тушаалаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлого горим"-ыг баталсан байна.

Уг НББББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2012 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

*санхүүгийн тайлан гаргах*", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.16-д *"Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**1.2** *__Өгсөн зөвлөмж__*: Бараа материалын ангиллыг стандартын дагуу үнэн зөв бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

4317143998
МЮА0065 9055436

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг илүү тайлагнасан, | 1 | 1,739.8 | | | 1 | 1,739.8 | 1 | 1,739.8 | | | | |
| Тээвэр шатахууны зардлыг илүү тайлагнасан, | 1 | 9,524.0 | | | 1 | 9,524.0 | 1 | 9,524.0 | | | | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг дутуу тайлагнасан | 1 | 11,263.8 | | | 1 | 11,263.8 | 1 | 11,263.8 | | | | |
| **Дүн** | **3** | **22,527.6** | | | **3** | **22,527.6** | **3** | **22,527.6** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өмнөх аудитаар өгсөн авлага барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. | 1 | 1,238.8 | | | 1 | 1,238.8 | | | | | | |
| Бараа материалыг ангиллын дагуу бус аж ахуйн материалд бүртгэн тайлагнасан | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **2** | 1,238.8 | | | **1** | 1,238.8 | **1** | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын зардлыг тухайн оны төсөвт тусгаж улирал бүр олгоогүй. | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | | | | | | **1** | |